

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хяргас сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2023/170/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Улаангом хот  
2023 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,  
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь  
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn  
Аудитын менежер: М.Бат-Амгалан  
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn  
Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн "Увс Финанс аудит" ХХК  
аудитор: С.Цэрэнминжин  
Утас: 89982722 Цахим хаяг:tseren8153@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**УВС АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,  
Ө.Бадрахын гудамж  
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,  
E-mail: uvs@audit.gov.mn

ХЯРГАС СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ТӨВИЙН ДАРГА Д.МЭНДБАЯР  
ТАНАА

2023.08.24 № УВА-2023/170/НН-СТА-ТМЗ

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хяргас сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хяргас сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Эрүүл мэндийн газраас үнэ төлбөргүй 2,275.0 мянган төгрөгийн машин, тоног төхөөрөмж ирж, төсвийн хөрөнгөөр 20,590.0 мянган төгрөгийн тавилга, эд хогшил худалдаж авсан байна.

**Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

0200200440

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	
Асуудлыг онцолсон хэсэг.....	
Аудитын гол асуудал.....	
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	
4.1 Ерөнхий зүйл .....	
4.2 Материаллаг байдал .....	
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	
4.5.1 Завсрын аудитын талаар .....	
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн .....	
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	
5.1 Залруулсан алдаа .....	
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НА	Нийцлийн аудит

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/Төгрөг/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>147,591,430.15</b>	<b>91,981,816.45</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	4,284,997.58	1,094,321.34
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	4,284,997.58	1,094,321.34
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	4,284,997.58	1,094,321.34
31211	Төрийн сангийн харилцах	3,330,747.58	1,094,321.34
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	954,250.00	00.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	75,204,986.97	1,585,854.81
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	68,044,720.00	00.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	7,160,266.97	1,585,854.81
3351	Байгууллагаас авах авлага	7,160,266.97	1,585,854.81
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	68,101,445.60	89,301,640.30
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	11,171,672.00	17,920,156.00
35130	Эм боох материал	11,171,672.00	17,920,156.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	56,929,773.60	71,381,484.30
35410	Бичиг хэргийн материал	867,100.00	1,748,200.00
35420	Аж ахуйн материал	30,992,583.84	33,872,018.84
35430	Сэлбэг хэрэгсэл	11,826,235.00	14,583,235.00
35440	Түлш, шатах тослох материал	01.00	01.00
35450	Барилгын засварын материал	2,004,100.00	5,938,650.00
35460	Хүнсний материал	2,663,392.76	6,471,018.46
35470	Бусад хангамжийн материал	8,576,361.00	8,768,361.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>731,805,729.81</b>	<b>705,138,011.48</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	731,805,729.81	705,138,011.48
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	710,765,729.81	684,098,011.48
39201	Барилга, байгууламж, орон сууц	599,664,291.11	608,764,291.11
39202	Хуримтлагдсан элэгдэл	-32,488,214.40	-42,749,619.24
39203	Авто-тээврийн хэрэгсэл	91,250,000.00	91,250,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-16,047,333.32	-33,883,333.28
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	105,880,999.40	116,646,027.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	-76,599,118.05	-89,038,292.64
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	46,193,261.40	49,193,261.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	-34,319,024.31	-37,249,823.22
39214	Бусад үндсэн хөрөнгө	38,364,715.00	38,364,715.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-11,133,847.02	-17,199,215.05
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	21,040,000.00	21,040,000.00
39301	Програм хангамж	440,000.00	440,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-440,000.00	-440,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	21,040,000.00	21,040,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>879,397,159.96</b>	<b>797,119,827.93</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,218,355.88</b>	<b>3,880,540.68</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	1,218,355.88	3,880,540.68
<b>413</b>	<b>Өглөг</b>	1,218,355.88	3,880,540.68
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	602,009.00	3,315,635.80

4136	Бусад өглөг	616,346.88	564,904.88
41361	Байгууллагад толох оглог	616,346.88	564,904.88
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>878,178,804.08</b>	<b>793,239,287.25</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>878,178,804.08</b>	<b>793,239,287.25</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	245,956,542.95	245,956,542.95
51101	Өмч: - төрийн	245,956,542.95	245,956,542.95
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>306,460,065.48</b>	<b>221,520,548.65</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	306,460,065.48	306,460,065.48
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-84,939,516.83
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	325,762,195.65	325,762,195.65
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>879,397,159.96</b>	<b>797,119,827.93</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөг/
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>794,687,425.00</b>	<b>613,279,667.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>88,825,400.00</b>	<b>25,738,818.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>88,825,400.00</b>	<b>25,738,818.00</b>
120001	Хувьцааны ногдол ашиг	5,400.00	2,275,028.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	88,820,000.00	22,878,790.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	78,570,000.00	22,878,790.00
120009	Бусад орлого	00.00	585,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО</b>	<b>705,862,025.00</b>	<b>587,540,849.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>390,201,900.00</b>	<b>00.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	390,201,900.00	00.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>191,098,180.00</b>	<b>00.00</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>32,729,300.00</b>	<b>35,648,100.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	32,729,300.00	35,648,100.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>91,832,645.00</b>	<b>551,892,749.00</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	91,832,645.00	551,892,749.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>642,420,215.92</b>	<b>698,943,118.83</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>642,420,215.92</b>	<b>698,943,118.83</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>609,659,356.62</b>	<b>664,515,019.75</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>336,935,414.00</b>	<b>392,603,334.75</b>
210101	Үндсэн цалин	336,584,664.00	392,603,334.75
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>46,760,900.61</b>	<b>49,295,461.45</b>
210201	Тэтгэврийн даатгал	37,826,305.61	32,948,265.02
210202	Тэтгэмжийн даатгал	1,839,315.00	4,113,560.99
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,219,251.00	3,140,680.41
210204	Ажилгүйдлийн даатгал	867,878.00	1,542,787.27
210205	Эрүүл мэндийн даатгал	4,008,151.00	7,550,167.76
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>30,368,440.70</b>	<b>30,669,050.92</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,659,777.70	2,959,957.22
210302	Түлш, халаалт	27,708,663.00	27,709,093.70
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>43,433,388.68</b>	<b>37,771,257.00</b>

210401	Бичиг хэрэг	11,454,509.68	1,905,650.00
210402	Тээвэр, шатахуун	30,382,479.00	30,925,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,225,800.00	1,703,307.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	490,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	370,600.00	2,747,300.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>102,154,503.30</b>	<b>94,541,069.30</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	90,377,379.00	80,523,240.00
210502	Хоол, хүнс	11,777,124.30	9,334,329.30
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	4,683,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>809,390.00</b>	<b>6,873,900.00</b>
210604	Урсгал засвар	809,390.00	6,873,900.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>364,000.00</b>	<b>652,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	364,000.00	652,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,251,500.00</b>	<b>926,500.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	860,000.00	288,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	238,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	238,500.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	334,000.00
210807	Газрын төлбөр	153,000.00	00.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>47,581,819.33</b>	<b>51,182,446.33</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,737,500.00	1,649,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хөрөгдөл	45,844,319.33	49,532,746.33
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>32,760,859.30</b>	<b>34,428,099.08</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>32,200,000.00</b>	<b>34,160,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	32,200,000.00	34,160,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>560,859.30</b>	<b>268,099.08</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	0.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>152,267,209.08</u></b>	<b><u>-85,663,451.83</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>152,267,209.08</u></b>	<b><u>-85,663,451.83</u></b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөг/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>637,817,305.00</u></b>	<b><u>656,170,569.00</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>585,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	00.00	585,000.00
120009	Бусад орлого	00.00	585,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>637,817,305.00</b>	<b>655,585,569.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	390,201,900.00	00.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	390,201,900.00	00.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	191,098,180.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	191,098,180.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	32,729,300.00	35,648,100.00

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	32,729,300.00	35,648,100.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	23,787,925.00	619,937,469.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	23,787,925.00	619,937,469.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>633,532,307.42</b>	<b>660,748,745.24</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>633,532,307.42</b>	<b>660,748,745.24</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>600,771,448.12</b>	<b>626,280,646.16</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	343,048,054.42	384,591,315.82
210101	Үндсэн цалин	304,997,100.42	264,345,709.68
210102	Нэмэгдэл	00.00	80,130,564.03
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,122,790.00	5,774,200.00
210104	Урамшуулал	27,888,174.00	29,338,510.11
210105	Гэрээт ажлын хөлс	5,039,990.00	5,002,332.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	44,828,288.00	50,406,941.42
210201	Тэтгэврийн даатгал	32,879,099.44	37,518,998.48
210202	Тэтгэмжийн даатгал	2,987,299.89	3,221,910.79
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,389,789.85	2,577,448.60
210204	Ажилгүйдлийн даатгал	597,499.04	644,362.10
210205	Эрүүл мэндийн даатгал	5,974,599.78	6,444,221.45
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	30,368,440.70	30,669,050.92
210301	Гэрэл, цахилгаан	2,659,777.70	2,959,957.22
210302	Түлш, халаалт	27,708,663.00	27,709,093.70
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	40,722,280.00	41,270,857.00
210401	Бичиг хэрэг	2,757,850.00	2,682,650.00
210402	Тээвэр, шатахуун	29,249,900.00	30,925,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,475,800.00	1,703,307.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,820,580.00	490,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,418,150.00	5,469,900.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	106,644,885.00	80,178,331.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	82,048,740.00	62,914,376.00
210502	Хоол, хүнс	14,498,645.00	12,580,455.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	10,097,500.00	4,683,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	31,384,500.00	35,205,450.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	14,350,000.00	8,490,000.00
210602	Тавилга	7,599,400.00	3,000,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	700,000.00	1,530,000.00
210604	Урсгал засвар	8,735,100.00	22,185,450.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	364,000.00	652,000.00
210702	Дотоод албан томилолт	364,000.00	652,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,111,500.00	926,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	288,000.00	288,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	183,700.00	238,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	54,800.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	432,000.00	334,000.00
210807	Газрын төлбөр	153,000.00	00.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	2,299,500.00	2,380,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,299,500.00	2,380,200.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>32,760,859.30</b>	<b>34,468,099.08</b>

2132	Бусад урсгал шилжүүлэг	32,200,000.00	34,200,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	32,200,000.00	34,200,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	560,859.30	268,099.08
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	0.00
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>4,284,997.58</b>	<b>-4,578,176.24</b>
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	4,284,997.58	-4,578,176.24
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	4,284,997.58
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,284,997.58	1,094,321.34

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	/төгрөг/	
				Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	245,956,542.95	325,762,195.65	306,460,065.48	878,178,804.08
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	245,956,542.95	325,762,195.65	306,460,065.48	878,178,804.08
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	245,956,542.95	325,762,195.65	306,460,065.48	878,178,804.08
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-85,107,029.35	-85,107,029.35
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	245,956,542.95	325,762,195.65	221,353,036.13	793,071,774.73

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	4,284,997.58	(4,284,997.58)
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	736,537,800.00	660,480,646.16	76,057,153.84
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	736,537,800.00	660,480,646.16	76,057,153.84
210	Бараа, үйлчилгээний зардал	702,337,800.00	626,280,646.16	76,057,153.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	425,087,500.00	384,591,315.82	40,496,184.18
210101	Үндсэн цалин	369,964,300.00	264,345,709.68	105,618,590.32
210102	Нэмэгдэл	-	80,130,564.03	(80,130,564.03)
210103	Унаа, болон бусад нөхөн олговор	5,808,000.00	5,774,200.00	33,800.00
210104	Урамшуулал	44,305,200.00	29,338,510.11	14,966,689.89
210105	I эрээт ажлын хөлс	5,010,000.00	5,002,332.00	7,668.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	67,189,800.00	50,406,941.42	16,782,858.58
210201	Тэтгэврийн даатгал	50,135,000.00	37,518,998.48	12,616,001.52
210202	Тэтгэмжийн даатгал	4,251,200.00	3,221,910.79	1,029,289.21
210203	ҮОМШӨ ний даатгал	3,450,900.00	2,577,448.60	873,451.40
210204	Ажилгүйдлийн даатгал	850,300.00	644,362.10	205,937.90
210205	Эрүүл мэндийн даатгал	8,502,400.00	6,444,221.45	2,058,178.55
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,929,300.00	30,669,050.92	260,249.08
210301	Гэрэл цахилгаан	2,900,000.00	2,959,957.22	(59,957.22)
210302	Түлш, халаалт	27,709,300.00	27,709,093.70	206.30
210303	Цэвэр, бохир ус	320,000.00	-	320,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	45,144,000.00	41,270,857.00	3,873,143.00
210401	Бичиг хэрэг	2,964,900.00	2,682,650.00	282,250.00
210402	Тээвэр (шатахуун)	31,617,300.00	30,925,000.00	692,300.00
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	1,818,800.00	1,703,307.00	115,493.00
210404	Ном, хэвлэл	75,100.00	-	75,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,097,700.00	490,000.00	2,607,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	5,570,200.00	5,469,900.00	100,300.00
2105	Нормативт зардал			

		86,278,200.00	80,178,331.00	6,099,869.00
210501	Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	66,588,100.00	62,914,376.00	3,673,724.00
210502	Хоол, хүнс	14,256,400.00	12,580,455.00	1,675,945.00
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	5,433,700.00	4,683,500.00	750,200.00
2106	Эд хогшил худалдан авах	38,090,800.00	35,205,450.00	2,885,350.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,250,000.00	8,490,000.00	4,760,000.00
210602	Тавилга	3,000,000.00	3,000,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	1,980,000.00	1,530,000.00	450,000.00
210604	Урсгал засвар	19,860,800.00	22,185,450.00	(2,324,650.00)
2107	Томилолт, зочны зардал	2,795,800.00	652,000.00	2,143,800.00
210702	Дотоод албан томилолт	2,795,800.00	652,000.00	2,143,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	2,975,200.00	926,500.00	2,048,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	150,000.00	-	150,000.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	468,000.00	288,000.00	180,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	541,100.00	238,500.00	302,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	79,200.00	-	79,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	138,100.00	66,000.00	72,100.00
210806	Мэдээллийн технологийн зардал	1,522,000.00	334,000.00	1,188,000.00
210807	Газрын төлбөр	76,800.00	-	76,800.00
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	3,847,200.00	2,380,200.00	1,467,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,847,200.00	2,380,200.00	1,467,000.00
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34,200,000.00	34,200,000.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	34,200,000.00	34,200,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	34,200,000.00	34,200,000.00	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	785,622,169.92	655,585,569.00	130,036,600.92
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	35,380,000.92	35,648,100.00	(268,099.08)
132001	Орон нутгийн төсвөөс	35,380,000.92	35,648,100.00	(268,099.08)
1340	НД-ЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	619,937,469.00	619,937,469.00	-
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	619,937,469.00	619,937,469.00	-
122	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	130,304,700.00	-	130,304,700.00
122001	Хандив тусламж /дотоод/	130,304,700.00	-	130,304,700.00

4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	4,284,997.58	(4,284,997.58)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,094,321.34	(1,094,321.34)
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	24.00	24.00	-
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-
620002	Гүйцэтгэх ажилтан	18.00	18.00	-
620003	Үйлчлэх ажилтан	4.00	4.00	-
620004	Гэрээт ажилтан	1.00	1.00	-

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хяргас сумын Эрүүл мэндийн төв нь эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, хүн амын эрүүл аж төрөх зан үйлд сургах хэвшүүлэх, эрүүлжүүлэхэд чиглэн үйл ажиллагаагаа явуулж байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Эрүүл мэндийн тухай хууль - 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдөр батлагдсан.
- ✓ Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль - 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан.
- ✓ Эрүүл мэндийн даатгалын тухай хууль - 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан.
- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль - 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр
- ✓ Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"
- ✓ Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 276 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт
- ✓ Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт

- ✓ Сангийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар тушаал "Албан томилолтын зардлын тариф" тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хяргас сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хяргас сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 26,667.7 мянган төгрөгөөр буюу 0.9 хувиар буурсан байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	4,284.9	1,094.3	3,190.9
Авлага	75,204.9	2,744.2	72,460.7
Бараа материал	68,101.4	89,301.6	21,200.2
Үндсэн хөрөнгө	731,805.7	705,138.0	26,667.7
Нийт хөрөнгө	879,397.1	800,636.2	78,760.9
Өр төлбөр	1218.3	6,840.5	5,622.1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	878,178.8	793,795.7	-84,383.1
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	879,397.1	800,636.2	-78,760.9

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 29,235.3 мянган төгрөгөөр буурсан нь Төсвийн шинэчлэл хэрэгжиж улсын төсвөөс санхүүжиж буй байгууллагуудын дансны үлдэгдлийг татан төвлөрүүлэхгүй байх шийдвэр хэрэгжсэнтэй холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 2,772.2 мянган төгрөг болж 72,460.7 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны санхүүжилтийг бүрэн авсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 89,301.6 мянган төгрөг болж 21,200.2 мянган төгрөгөөр өссөн нь худалдан авсан бараа материалаас шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй болно.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 705,138.0 мянган төгрөг болж өссөн нь 20,590.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, барилга байгууламжид 9,100.0 мянган төгрөгийн хашаа үндсэн хөрөнгөд нэмсэнтэй холбоотой.

Өр төлбөр дансны эхний үлдэгдэл 6,840.5 мянган төгрөг болж 5,622.1 мянган төгрөгөөр өссөн нь татварын өр төлбөрөөс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 878,178.8 мянган төгрөг болж 84,383.1 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэлээс шалтгаалж буурсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар тайлант үеийн үр дүн нь 879,397.1 мянган төгрөг болж өмнөх оны үр дүнгээс 78,760.9 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 558,523.0 мянган төгрөг, нийт зарлагыг 558,523.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 32,772.2 мянган төгрөгөөр бууруулж баталсан байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 696,897.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 696,897.0 мянган төгрөгөөр тооцон төсвийн захирагчидад хүргүүлсэн байна.

Анх батлагдсан төсвөөс тодотголоор 18,188.0 мянган төгрөгөөр бууруулан 678,709.0 мянган төгрөг баталсан.

Эрүүл мэндийн даатгалаас 619,937.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 35,648.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд улсын төсвийн 623,922.6 мянган төгрөгийг зарцуулж, улсын төсвийн дансанд 1094.3 мянган

төгрөгийн үлдэгдэлтэй байна. Орон нутгийн төсвийн 268.1 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

				/мянган төгрөгөөр/	
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Улсын төсвөөс	623,922.6	622,828.3	1,095.3	99.8%
	Орон нутгийн төсвөөс	35,648.1	35,380.0	268.1	99.1%

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд Хяргас сумын Эрүүл мэндийн төвийн нэмэлт санхүүжилтийн дансаар орлого, зарлага гараагүй байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Хяргас сумын Эрүүл мэндийн төв нь тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хяргас сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Увс Финанс Аудит” ХХК-ийн аудитор С.Цэрэнминжин гүйцэтгэж, анхан шатны хяналтыг захирал Я.Нарантуяа, чанарын хяналтыг Увс аймгийн Төрийн аудитын газрын аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Хяргас сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Увс Финанс Аудит” ХХК –д 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 05 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 642.4 сая төгрөгөөс 1 хувиар буюу 6.4 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 698.9 сая төгрөгийн 1 хувиар буюу 6.9 сая төгрөгөөр тогтоосон.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Хяргас сумын Эрүүл мэндийн төвийн хувьд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хамаарах зүйл заалтын хүрээнд зөрчил гараагүй байна. /АБ-4/

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс байршуулах хугацаа болоогүй 2, хугацаа хоцорсон 8, хугацаандаа оруулсан 146 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилт**

Хяргас сумын Эрүүл мэндийн төв нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэгт "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Хяргас сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар зөрчил арилгуулах 1 албан шаардлага, 1 төлбөрийн акт тогтоосныг биелэлтийг бүрэн хангаж ажилласан байна.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хяргас сумын Эрүүл мэндийн төвийн хувьд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1760.4 мянган төгрөгийн алдаа илэрснийг залрууллаа.

#### 5.1 Залруулсан алдаа

1. Нягтлан бодох бүртгэлийн тухай 5 дүгээр зүйлийн 5.1.4 дэх заалтад "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв байх зарчмыг баримтална" гэж заасныг зөрчин 620.0 мянган төгрөгийн өр төлбөр, 1,158.4 мянган төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд буруу тайлагнасныг залруулга хийлгэлээ.

### 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Буруу тусган илэрхийлсэн	2	1,760.4			2	1,760.4	2	1,760.4				
Дүн	2	1,760.4			2	1,760.4	2	1,760.4				

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М. БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР

/М. БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

"УВС ФИНАНС АУДИТ" ХХК-ийн  
АУДИТОР

/С.ЦЭРЭНМИНЖИН/

2023 оны 02 дугаар сарын 18-ны өдөр